

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООДЫН
ХАМТАРСАН

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 12 дугаар сарын 04-ний өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4 – 6

- “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын
1. тогтоолын төсөл /Засгийн газар 2025.11.19-ний өдөр
өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

5 – 6

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хороодын
12 дугаар сарын 04-ний өдөр /Пүрэв гараг/-ийн хамтарсан
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хамтарсан хуралдаанд ирвэл зохих 55 гишүүнээс 28 гишүүн хүрэлцэн ирж, 50.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 17 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: П.Ганчимэг, Г.Ганбаатар, С.Ганбаатар, С.Лүндэг, Ц.Мөнхбат, Л.Мөнхбаясгалан, Р.Сэддорж, Ц.Туваан, А.Ундраа;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, П.Батчимэг, Х.Ганхуяг, Д.Жаргалсайхан;

Тасалсан: Ж.Алдаржавхлан, О.Амгаланбаатар, Д.Батбаяр, Р.Батболд, Ж.Баясгалан, Х.Болормаа, Х.Булгантуяа, П.Ганзориг, П.Мөнхтулга, З.Мэндсайхан, Ч.Номин, Д.Энхтүвшин.

Нэг. “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.11.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/ үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Гаалийн ерөнхий газрын Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Чимгэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Бадралт, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Д.Үүрийнтуяа: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Д.Үүрийнтуяа нарын гаргасан, Тогтоолын төслийн 5 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18

Татгалзсан: 11

Бүгд: 29

62.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Д.Үүрийнтуяа нарын гаргасан, Төслийн нэрийг “Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж, төслийн 2, 3, 4 дэх заалтын “мөн тогтоолын” гэснийг “Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 9
Бүгд: 29
69.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хамтарсан хуралдаан 07 минут үргэлжилж, 55 гишүүнээс 29 гишүүн хүрэлцэн ирж, 52.7 хувийн ирцтэйгээр 10 цаг 24 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН,
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Х.ГАНХУЯГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 12 дугаар сарын 04-ний өдөр, Пүрэв гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
10 цаг 17 минут

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Үүрийнтуяа: Байнгын хороодын эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Төсвийн байнгын хороо, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хамтарсан хуралдаан хуралдаанд гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 50.9 хувиар бүрдсэн тул 2025 оны 12 сарын 04-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Төсвийн байнгын хорооны гишүүдээс хуралдаанд оролцож байгаа гишүүдийг нэр, тойргоор танилцуулна.

Норовын Алтанхуяг 11 дүгээр тойрог, Тилеуханы Аубакир 3 дугаар тойрог, Жигжидийн Батжаргал 5 дугаар тойрог, Жамбын Батсуурь жагсаалт, Жамбалын Ганбаатар 9 дүгээр тойрог, Цэрэнпилийн Даваасүрэн 4 дүгээр тойрог, Пүрэвжавын Сайнзориг 11 дүгээр тойрог, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан 1 дүгээр тойрог, Баатаржавын Мөнхсоёл жагсаалт, Нанзадын Наранбаатар 7 дугаар тойрог, Даваахүүгийн Пүрэвдаваа жагсаалт, Ганзоригийн Тэмүүлэн 1 дүгээр тойрог, Доржсүрэнгийн Үүрийнтуяа 4 дүгээр тойрог, Даваагийн Цогтбаатар 1 дүгээр тойрог, Баттогтохын Чойжилсүрэн 2 дугаар тойрог.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны гишүүдийг танилцуулъя.

Буланы Бейсен 3 дугаар тойрог, Наранцэцэгийн Алтаншагай 11 дүгээр тойрог, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ 4 дүгээр тойрог, Мөнгөнцогийн Ганхүлэг 6 дугаар тойрог, Дамдинсүрэн Жаргалсайхан 1 дүгээр тойрог, Сонгобайн Замира жагсаалт, Жаргалсайханы Золжаргал 9 дүгээр тойрог, Цагаанхүүгийн Идэрбат 6 дугаар тойрог, Мэндбаярын Мандхай жагсаалт, Тогтмолын Мөнхсайхан 12 дугаар тойрог, Баатаржавын Мөнхсоёл жагсаалт, Нанзадын Наранбаатар 7 дугаар тойрог, Салдангийн Одонтуяа жагсаалт, Ухнаагийн Отгонбаяр 6 дугаар тойрог, Болдын Уянга жагсаалт, Жигжидсүрэнгийн Чинбүрэн 8 дугаар тойрог.

Байнгын хороодын хамтарсан хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.
/алх цохив/

Хамтарсан хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулж санал, дүгнэлтээ чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн алга байна. /алх цохив/

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг. “Тогтоолд нэмэлт оруулах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл
/Засгийн газар 2025.11.19-ний өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан ажлын хэсгийг оруулъя.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Төмөрхуягийн Жамбалцэрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Даваасүрэнгийн Есөн-Эрдэнэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Даваасүрэнгийн Довчинсүрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хүнсний үйлдвэрийн Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Чойдоржийн Чимгэрэл Гаалийн ерөнхий газрын Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч.

2025 оны 12 сарын 02-ны өдрийн Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороодын хамтарсан хуралдаанаар “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулахад гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан.

Одоо тогтоолын төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгээрэй.

Зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Хоёр санал ирсэн байгаа. Саналыг танилцуулъя.

Нэгдүгээрт нь, Тогтоолын төслийн 5 дахь заалтыг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Д.Үүрийнтуяа. Санал хураалт. /алх цохив/

Санал 29 гишүүнээс 18 гишүүн дэмжиж, 62.1 хувиар дэмжигдлээ.

Хоёр дахь зарчмын зөрүүтэй санал. Найруулгын санал байна.

Төслийн нэрийг “Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж, төслийн 2, 3, 4 дэх заалтын “мөн тогтоолын” гэснийг “Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Д.Үүрийнтуяа. Санал хураалт. /алх цохив/

29 гишүүнээс 20 гишүүн дэмжиж, 69 хувиар санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж дууслаа. /алх цохив/

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хамтарсан хуралдааны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандхай танилцуулна.

Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хамтарсан хуралдаан үүгээр дууслаа. Эрхэм гишүүдэд баярлалаа. /алх цохив/

Хамтарсан хуралдаан 07 минут үргэлжилж, 10 цаг 24 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД